

МОНГОЛ УЛСЫН ЭРҮҮГИЙН ХУУЛЬ

ЕРӨНХИЙ АНГИ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ Нийтлэг үндэслэл

1 дүгээр зүйл. Монгол Улсын Эрүүгийн хуулийн зорилт

1. Монгол Улсын Эрүүгийн хуулийн зорилт нь Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт болон үндэсний аюулгүй байдал, хүний амь бие, эрүүл мэнд, түүний эрх, эрх чөлөө, нийтийн болон хувийн өмч, үндэсний баялаг, байгаль орчин, түүнчлэн эрх зүйн журмыг гэмт халдлагаас хамгаалахад оршино.

2. Монгол Улсын Эрүүгийн хууль энэ зорилтыг хэрэгжүүлэхийн тулд нийгэмд аюултай ямар хэрэг гэмт хэрэг болохыг тодорхойлж, гэмт хэрэг үйлдсэн этгээдэд оногдуулбал зохих ял болон эрүүгийн хариуцлагын бусад арга хэмжээг тогтооно.

[/Энэ зүйлийг 1993 оны 6 дугаар сарын 7-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

1¹ дүгээр зүйл. Монгол Улсын Эрүүгийн хуулийн зарчим

1. Монгол Улсын Эрүүгийн хууль нь шударга, энэрэнгүй, ёс, хуулийг чанд сахих, хүн бүр хууль шүүхийн өмнө эрх тэгш байх, гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай этгээд зөвхөн өөрөө хариуцлага хүлээх, хариуцлага гарцаагүй байх зарчимд үндэслэнэ.

2. Гэмт хэрэг үйлдсэн этгээдэд түүний үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролыг үл харгалзан энэ хуульд заасны дагуу эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.

[/Энэ зүйлийг 1993 оны 6 дугаар сарын 7-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

2 дугаар зүйл. Эрүүгийн хариуцлагын үндэслэл

1. Зөвхөн гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай, өөрөөр хэлбэл Эрүүгийн хуульд заасан нийгэмд аюултай хэргийг санаатай буюу болгоомжгүй үйлдсэн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэж, ял оногдуулна.

2. Гэм буруутай нь хуулийн дагуу шүүхээр нотлогдох хүртэл хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож үл болно. Эрүүгийн ял болон эрүүгийн хариуцлагын бусад арга хэмжээг зөвхөн хуульд нийцүүлэн гаргасан шүүхийн таслан шийдвэрлэх тогтоолоор оногдуулна. /Энэ хэсгийг 1993 оны 6 дугаар сарын 7-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./

3 дугаар зүйл. Эрүүгийн хуулийн үйлчлэх нутаг дэвсгэр, хамаарах этгээд

1. Монгол Улсын нутаг дэвсгэрт гэмт хэрэг үйлдсэн бүх этгээдэд энэ хуулиар хариуцлага хүлээлгэнэ.

2. Гадаад улсын дипломат төлөөлөгчид болон дагаж мөрдөж байгаа хууль, олон улсын гэрээний дагуу Монгол Улсын шүүхэд эрүүгийн хэргийн талаар харьяалагдахгүй бусад иргэн Монгол Улсын нутаг дэвсгэрт гэмт хэрэг үйлдвэл тэдэнд эрүүгийн хариуцлага хүлээлгэх асуудлыг дипломат шугамаар шийдвэрлэнэ.

3. Тус улсын хилийн гадна гэмт хэрэг үйлдсэн Монгол Улсын иргэн, харьяалалгүй этгээд Монгол Улсын нутаг дэвсгэрт эрүүгийн хариуцлагад татагдсан буюу шүүхэд шилжсэн бол тэдэнд энэ хуулиар хариуцлага хүлээлгэнэ. Эдгээр хүмүүс үйлдсэн гэмт хэрэгтээ хилийн гадна ял эдэлсэн бол шүүх тэдэнд оногдсон ялыг энэ хуулийн дагуу хөнгөрүүлж буюу гэм буруутай этгээдийг ял эдлэхээс бүрмөсөн чөлөөлж болно. Хэрэв Монгол Улсын олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол шүүх тухайн этгээдийг энэ хуульд заасан үндэслэлээр гэм буруугүй тооцож болно.

4. Монгол Улсын хилийн гадна гэмт хэрэг үйлдсэн гадаад улсын иргэнд Монгол Улсын олон улсын гэрээнд заасан тохиолдолд энэ хуулиар хариуцлага хүлээлгэнэ.

5. Монгол Улсын иргэнийг эрүүгийн хэрэгт мөрдүүлэх буюу ял шийтгүүлэхээр гадаад улсад шилжүүлж өгөхгүй.

4 дүгээр зүйл. Эрүүгийн хуулийн үйлчлэх цаг хугацаа

1. Хэргийг гэмт хэрэгт тооцох, түүнд ял шийтгэх эсэхийг уг хэргийг үйлдэх үед дагаж мөрдөж байсан хуулиар тодорхойлно.

2. Ял шийтгэхгүй болгосон буюу ялыг хөнгөрүүлсэн хууль буцаан хэрэглэх хүчинтэй, өөрөөр хэлбэл уг хууль түүнийг хүчин төгөлдөр болохын өмнө үйлдэгдсэн хэрэгт хамаарна.

3. Ял шийтгэх болсон буюу ялыг хүндрүүлсэн хуулийг буцаан хэрэглэхгүй.

ХОЁРДУГААР БҮЛЭГ ГЭМТ ХЭРГИЙН ТУХАЙ

5 дугаар зүйл. Гэмт хэргийн ойлголт

1. Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт болон үндэсний аюулгүй байдал, хүний амь бие, эрүүл мэнд, түүний эрх, эрх чөлөө, нийтийн болон хувийн өмч, үндэсний баялаг, байгаль орчин, түүнчлэн эрх зүйн журамд халдсан бөгөөд Эрүүгийн хуульд заасан, нийгэмд аюултай хэрэг/үйлдэл, эс үйлдэхүй/-ийг гэмт хэрэг гэж үзнэ. /Энэ хэсгийг 1993 оны 6 дугаар сарын 7-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./

2. Энэ хуулийн тусгай ангид заасан хэргийн шинжийг хэлбэрийн төдий агуулсан боловч ялимгүй учир нийгэмд аюулгүй үйлдэл буюу эс үйлдлийг гэмт хэрэгт тооцохгүй.

6 дугаар зүйл. Гэмт хэргийн ангилал

Гэмт хэргийн шинж чанар, хор аюулын хэр хэмжээг харгалзан хөнгөн, хүндэтэр, хүнд, онц хүнд гэмт хэрэг гэж ангилна:

а/энэ хуулийн тусгай ангид хоёр жилээс дээшгүй хугацаатай хорих ял буюу өөр төрлийн ял оногдуулахаар заасан санаатай гэмт хэрэг, түүнчлэн таван жилээс дээш хугацаатай хорих ял буюу өөр төрлийн ял оногдуулахаар заасан болгоомжгүй гэмт хэргийг хөнгөн гэмт хэрэг гэж үзнэ;

б/энэ хуулийн тусгай ангид таван жилээс дээшгүй хугацаатай хорих ял оногдуулахаар заасан санаатай гэмт хэрэг, түүнчлэн таваас дээш жилийн хугацаатай хорих ял оногдуулахаар заасан болгоомжгүй гэмт хэргийг хүндэтэр гэмт хэрэг гэж үзнэ;

в/энэ хуулийн тусгай ангид арван таван жил хүртэл хугацаатай хорих ял оногдуулахаар заасан санаатай гэмт хэргийг хүнд гэмт хэрэг гэж үзнэ;

г/энэ хуулийн тусгай ангид хорин таван жил хүртэл хугацаатай хорих ял буюу цаазаар авах ял оногдуулахаар заасан санаатай гэмт хэргийг онц хүнд гэмт хэрэг гэж үзнэ.

[/Энэ зүйлийг 1993 оны 6 дугаар сарын 7-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

7 дугаар зүйл. Гэмт хэрэг санаатай үйлдэх

Гэмт хэрэг үйлдсэн этгээд өөрийн үйлдэл буюу эс үйлдлийн нийгэмд аюултай шинж чанарыг ухамсарлаж, түүнээс учирч болох нийгэмд аюултай хор уршгийг урьдаас мэдсээр атал хүссэн, эсхүл тэр хор уршигт зориуд хүргэсэн бол гэмт хэрэг санаатай үйлдсэн гэж үзнэ.

8 дугаар зүйл. Гэмт хэрэг болгоомжгүй үйлдэх

Гэмт хэрэг үйлдсэн этгээд өөрийн үйлдэл буюу эс үйлдэл нийгэмд аюултай хор уршигт хүргэж болохыг урьдаас мэдсэн боловч тэр хор уршгийг гаргахгүй байж чадна гэж хөнгөмсөгөөр найдсан, эсхүл хор уршиг учруулна гэдгийг урьдаас мэдэх ёстой, мэдэх бололцоотой байсан атлаа мэдэлгүй үйлдсэн бол гэмт хэргийг болгоомжгүй үйлдсэн гэж үзнэ.

9 дүгээр зүйл. Насанд хүрээгүй этгээдэд хүлээлгэх эрүүгийн хариуцлага

1. Гэмт хэрэг үйлдэхийн өмнө арван зургаан насанд хүрсэн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.

2. Арван дөрвөөс арван зургаа хүртэл насны этгээд зөвхөн бусдыг алах /86 дугаар зүйл/; бусдын бие махбодид хүнд буюу хүндэтэр гэмтэл санаатай учруулах /90, 91, 93, 94, 95, 97 дугаар зүйл/; хүчиндэх /112 дугаар зүйл/; бусдын эд хөрөнгийг хулгайлах, булаах, дээрэмдэх /123, 124, 125 дугаар зүйл/; хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар бусдын эд хөрөнгийг санаатай устгах, гэмтээх /134 дүгээр зүйлийн хоёр дахь хэсэг/; хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар танхайрах /239 дүгээр зүйлийн хоёр, гурав дахь хэсэг/; зам харилцаа, тээврийн хэрэгслийг гэмтээх /266 дугаар зүйл/ гэмт хэрэг үйлдсэн бол түүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ. /Энэ хэсгийг АИХТ-ийн 1990 оны 52 дугаар зарлиг, 1993 оны 6 дугаар сарын 7-ны өдрийн хуулиар тус тус өөрчлөн найруулсан./

3. Арван найман насанд хүрэхийн өмнө нийгмийн аюулаар их биш гэмт хэрэг үйлдсэн этгээдийг эрүүгийн ял хэрэглэхгүйгээр засан хүмүүжүүлэх боломжтой гэж шүүх үзвэл түүнд энэ хуулийн 59 дүгээр зүйлд заасан хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэж болно.

4. Энэ зүйлийн гурав дахь хэсэгт заасан нөхцөлд насанд хүрээгүй этгээдийг эрүүгийн хариуцлагаас чөлөөлж, түүнд хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх асуудлыг хэлэлцүүлэхээр орон нутгийн Ардын Депутатуудын хурлын гүйцэтгэх захиргааны дэргэдэх насанд хүрээгүй хүмүүсийн хэрэг эрхлэх комисст шилжүүлж болно.

10 дугаар зүйл. Хэрэг хариуцах чадваргүй байдал

1. Нийгэмд аюултай хэрэг үйлдэх үедээ хэрэг хариуцах чадваргүй, өөрөөр хэлбэл сэтгэл мэдрэлийн архаг өвчтэй, сэтгэл мэдрэлийн үйл ажиллагаа нь түр сарнисан, эсхүл оюун ухааны хомсдолтой буюу өөр бусад өвчний улмаас өөрийн үйлдлийг хариуцаж буюу жолоодож чадахгүй байсан этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүй. Ийм этгээдэд шүүхийн зааснаар энэ хуулийн 55 дугаар зүйлд заасан эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэж болно.

2. Түүнчлэн гэмт хэрэг үйлдэх үедээ хэрэг хариуцах чадвартай байсан боловч шүүхийн таслан шийдвэрлэх тогтоол гарахын өмнө сэтгэл мэдрэлийн өвчнөөр өвчилж өөрийн үйлдлийг хариуцаж буюу жолоодож чадахгүй болсон этгээдэд ял оногдуулж болохгүй. Ийм этгээдэд шүүхийн зааснаар эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэж, эдгэрсний нь дараа ял оногдуулж болно.

11 дүгээр зүйл.Согтуурсан буюу мансуурсан байдалд гэмт хэрэг үйлдсэн этгээдэд хүлээлгэх эрүүгийн хариуцлага

Согтуурсан буюу мансуурсан байдалд гэмт хэрэг үйлдсэн этгээдийг эрүүгийн хариуцлагаас чөлөөлөхгүй.

12 дугаар зүйл.Аргагүй хамгаалалт

- 1.Аргагүй хамгаалалтын байдалд, өөрөөр хэлбэл, улс, нийтийн эрх ашиг, өөрийн болон бусдын амь бие, эрүүл мэнд, эрхийг нийгэмд аюултай халдлагаас хамгаалахын тулд энэ хуулийн тусгай ангийн 89, 93 дугаар зүйлд зааснаас бусад үйлдлийг халдагчид гэм хор учруулах замаар хийснийг гэмт хэрэгт тооцохгүй. /Энэ хэсгийг 1997 оны 12 дугаар сарын 5-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./
- 2.Хамгаалалт нь халдлагын шинж чанар, аюулаас илт давсан байвал аргагүй хамгаалалтын хэр хэмжээг хэтрүүлсэн гэж үзнэ.
- 3.Гэм буруутай этгээдийг саатуулахын тулд хохирогч буюу бусад хүнээс энэ хуулийн тусгай ангид заасан үйлдлийг хийсэн бол аргагүй хамгаалалттай адилтгаж үзнэ.

13 дугаар зүйл.Гарцаагүй байдал

Гарцаагүй байдалд, өөрөөр хэлбэл улс, нийгмийн эрх ашиг, өөрийн болон бусдын амь бие, эрүүл мэнд, эрхэд заналхийлсэн аюулыг зайлуулахын тулд энэ хуулийн тусгай ангид заасан үйлдлийг хийсний улмаас учирсан хохирол нь учирч болох байсан хохирлоос бага бөгөөд уг аюулыг тухайн нөхцөл байдалд өөр аргаар зайлуулах боломжгүй байвал уг үйлдлийг гэмт хэрэгт тооцохгүй.

14 дүгээр зүйл.Гэмт хэрэг үйлдэхээр бэлтгэсэн буюу завдсан этгээдэд хүлээлгэх эрүүгийн хариуцлага

- 1.Гэмт хэрэг үйлдэхийн тулд зэвсэг, хэрэгслийг хайж олсон, төхөөрч тохируулсан буюу бусад нөхцөлийг санаатай бүрдүүлснийг гэмт хэрэг үйлдэхээр бэлтгэсэн гэж үзнэ.
- 2.Гэмт хэрэг үйлдэхэд шууд чиглэсэн үйлдлийг санаатай хийсэн боловч гэм буруутай этгээдийн хүсэл зоригоос үл хамаарах шалтгаанаар гэмт хэрэг туйлдаа хүрээгүй бол гэмт хэрэг үйлдэхээр завдсан гэж үзнэ.
- 3.Гэмт хэрэг үйлдэхээр бэлтгэсэн буюу завдсан бол тухайн гэмт хэрэгт хариуцлага хүлээлгэхээр заасан энэ хуулийн тусгай ангийн зохих зүйлийн дагуу ял оногдуулна.
- 4.Шүүх ял оногдуулахдаа гэм буруутай этгээдийн хийсэн үйлдлийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, гэмт санаагаа хэрэгжүүлсэн хэр хэмжээ, гэмт хэрэг туйлдаа хүрээгүй шалтгааныг харгалзан үзнэ.

15 дугаар зүйл.Гэмт хэрэг үйлдэхээс сайн дураар татгалзах

- 1.Гэмт хэргээ туйлд нь хүргэхээс сайн дураар, төгс татгалзсан этгээдийг эрүүгийн хариуцлагаас чөлөөлнө.
- 2.Хэрэв гэмт хэргээ туйлд нь хүргэхээс сайн дураар татгалзахын өмнө үйлдсэн хэрэг нь өөр гэмт хэргийн бүрэлдэхүүнийг агуулж байвал зөвхөн тэр хэрэгт нь эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.

16 дугаар зүйл.Хамтран оролцогчид

- 1.Гэмт хэрэг үйлдэхэд санаатай нэгдэн оролцсон хоёр буюу түүнээс дээш этгээдийг хамтран оролцогчид гэнэ.
- 2.Гүйцэтгэгчээс гадна зохион байгуулагч, хатгагч, хамжигчийг гэмт хэрэгт хамтран оролцогч гэж үзнэ:
 - а/гэмт хэргийг шууд гардан үйлдсэн этгээдийг гүйцэтгэгч;
 - б/гэмт хэрэг үйлдэхийг зохион байгуулсан буюу удирдсан этгээдийг зохион байгуулагч;
 - в/гэмт хэрэг үйлдэхэд өдөөн түлхсэн этгээдийг хатгагч;
 - г/зааж, зөвлөх, зэвсэг, хэрэгсэл өгөх, учрах саадыг арилгах замаар гэмт хэрэг үйлдэхэд дэмжлэг үзүүлсэн, түүнчлэн гэмт хэрэгтэн болон гэмт хэрэг үйлдэхэд хэрэглэсэн зэвсэг, хэрэгсэл, гэмт хэрэг үйлдэж олсон эд зүйлийг нуун далдлах, гэмт хэргийн ул мөрийг баллахаар урьдчилан амласан этгээдийг хамжигч гэнэ.
- 3.Шүүх ял оногдуулахдаа хамтран оролцогч бүрийн гэмт хэрэг үйлдэхэд оролцсон шинж чанар, хэр хэмжээг харгалзан үзнэ.

16¹ дүгээр зүйл.Гэмт хэрэг үйлдсэн зохион байгуулалттай бүлэг

- 1.Гэмт хэрэг үйлдэхийн тулд урьдчилан нэгдэж, зохион байгуулагдсан бөгөөд тогтвортой ажилладаг хоёр буюу түүнээс дээш этгээдийг зохион байгуулалттай бүлэг гэнэ.
- 2.Зохион байгуулалттай бүлэг этгээдэд хүлээлгэх эрүүгийн хариуцлагыг энэ хуулийн тусгай ангид тогтооно.
[/Энэ зүйлийг 1993 оны 6 дугаар сарын 7-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

17 дугаар зүйл.Нуун далдлах

Гэмт хэрэгтэнг болон гэмт хэрэг үйлдэхэд хэрэглэсэн зэвсэг хэрэгсэл, гэмт хэргийн ул мөр, гэмт хэрэг үйлдэж олсон эд зүйлийг урьдчилан амлалгүйгээр нуун далдалсан бол зөвхөн энэ хуулийн тусгай ангид заасан тохиолдолд эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.

18 дугаар зүйл. Үл мэдээлэх

Гэмт хэрэг үйлдэхээр бэлтгэж байгааг буюу үйлдсэнийг лавтай сайн мэдэж байгаад зохих байгууллага буюу албан тушаалтанд мэдээлээгүй бол зөвхөн энэ хуулийн тусгай ангид заасан тохиолдолд эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.

ГУРАВДУГААР БҮЛЭГ ЯЛЫН ТУХАЙ

19 дүгээр зүйл. Ял, түүний зорилго

1. Ял нь гэмт хэрэг үйлдэж, гэм буруутайд тооцогдсон этгээдийн эрх, эрх чөлөөнд энэ хуульд заасны дагуу шүүхийн таслан шийдвэрлэх тогтоолоор хязгаарлалт тогтоосон төрийн албадлагын арга хэмжээ мөн.
2. Ялын зорилго нь гэмт халдлагаас иргэн, нийгмийг хамгаалах, гэмт хэрэг үйлдсэн этгээдийг цээрлүүлэх, засан хүмүүжүүлэх, түүнчлэн ялтныг болон бусад хүнийг гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэхэд оршино.
3. Ял нь хүнлэг бус, хүнд хэрцгий хандах, нэр төрийг нь доромжлох зорилго агуулж болохгүй.
4. Гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай этгээдэд оногдуулсан ялыг түүний гэр бүлийн гишүүд, төрөл саданд нь халдаан хэрэглэхийг хориглоно.

[/Энэ зүйлийг 1993 оны 6 дугаар сарын 7-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

20 дугаар зүйл. Ялын төрөл

1. Гэмт хэрэг үйлдсэн этгээдэд дор дурдсан төрлийн ялыг хэрэглэж болно. :

а/торгох;

б/тодорхой албан тушаал эрхлэх буюу тодорхой үйл ажиллагаа явуулах эрхийг хасах;

в/эд хөрөнгө хураах;

г/засан хүмүүжүүлэх ажил хийлгэх;

д/хорих;

е/цаазаар авах.

2. Торгох, засан хүмүүжүүлэх ажил хийлгэх, хорих, цаазаар авах ялыг үндсэн ялын чанартай; тодорхой албан тушаал эрхлэх буюу тодорхой үйл ажиллагаа явуулах эрхийг хасах ялыг үндсэн болон нэмэгдэл ялын чанартай; эд хөрөнгө хураах ялыг зөвхөн нэмэгдэл ялын чанартай хэрэглэнэ.

[/Энэ зүйлийг 1993 оны 6 дугаар сарын 7-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

21 дүгээр зүйл. Ялын дээд хэмжээ-цаазаар авах ял

1. Онц хүнд гэмт хэрэг үйлдсэн этгээдэд энэ хуулийн тусгай ангид заасан тохиолдолд цаазаар авах-буудан алах ял оногдуулна.
2. Цаазаар авах ял шийтгүүлсэн этгээдийн амийг уучилсан тохиолдолд хугацаагүй хорих ялаар солино.
3. Арван найман насанд хүрэхийн өмнө гэмт хэрэг үйлдсэн этгээд, түүнчлэн эмэгтэйчүүд, жараас дээш насны эрэгтэйчүүдэд цаазаар авах ял оногдуулж болохгүй.

[/Энэ зүйлийг 1993 оны 6 дугаар сарын 7-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

22 дугаар зүйл. Хорих

1. Хорих ялын үндсэн хугацаа зургаан сараас арван таван жил хүртэл байна. Онц хүнд гэмт хэрэг үйлдсэн этгээдэд энэ хуулийн тусгай ангид заасан тохиолдолд хорин таван жил хүртэл хугацаатай хорих ял оногдуулна. /Энэ хэсгийг 1993 оны 6 дугаар сарын 7-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./
2. Арван найман насанд хүрэхийн өмнө гэмт хэрэг үйлдсэн этгээд, тавин таваас дээш насны эмэгтэйчүүд, жараас дээш насны эрэгтэйчүүдэд арван таван жилээс дээш хугацаагаар хорих ял оногдуулж болохгүй. /Энэ хэсгийг 1993 оны 6 дугаар сарын 7-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./
3. Энэ хуулийн 27 дугаар зүйлийн дөрөв дэх хэсэгт заасан тохиолдолд хорих ялын хугацаа зургаан сараас доош байж болно.
4. Шүүхийн таслан шийдвэрлэх тогтоолоор хорих ялыг жирийн, чанга, онцгой дэглэмтэй засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн колонид буюу гянданд, түүнчлэн жирийн болон чанга дэглэмтэй хүмүүжил-хөдөлмөрийн колонид эдлүүлэхээр оногдуулна.
5. Хөнгөн буюу хүндэтэр гэмт хэрэг санаатай үйлдэж анх удаа хорих ял шийтгүүлсэн, хүнд буюу онц хүнд гэмт хэрэгт гурван жилээс дээшгүй хугацаагаар анх удаа хорих ял шийтгүүлсэн буюу гэмт хэрэг болгоомжгүй үйлдэж хорих ял шийтгүүлсэн эрэгтэйчүүд, түүнчлэн төрийн эсрэг онц аюултай гэмт хэрэгт хорих ял шийтгүүлсэн буюу онц аюултай гэмт хэрэгтнээр тооцогдсоноос бусад эмэгтэйчүүдийн хорих ялыг жирийн дэглэмтэй засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн колонид эдлүүлэхээр оногдуулна. /Энэ хэсгийг 1993 оны 6 дугаар сарын 7-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./

6.Төрийн эсрэг онц аюултай гэмт хэрэгт хорих ял шийтгүүлсэн, хүнд буюу онц хүнд гэмт хэрэгт гурван жилээс дээш хугацаагаар анх удаа хорих ял шийтгүүлсэн буюу урьд хорих ял эдэлж байсан эрэгтэйчүүд, төрийн эсрэг онц аюултай гэмт хэрэгт хорих ял шийтгүүлсэн буюу онц аюултай гэмт хэрэгтнээр тооцогдсон эмэгтэйчүүдийн хорих ялыг чанг дэглэмтэй засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн колонид эдлүүлэхээр оногдуулна. /Энэ хэсгийг 1993 оны 6 дугаар сарын 7-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./

7.Онц аюултай гэмт хэрэгтнээр тооцогдсон эрэгтэйчүүдийн хорих ялыг онцгой дэглэмтэй засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн колонид эдлүүлэхээр оногдуулна. /Энэ хэсгийг 1993 оны 6 дугаар сарын 7-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./

8.Хөнгөн буюу хүндэвтэр гэмт хэрэгт анх удаа хорих ял шийтгүүлсэн буюу хүнд буюу онц хүнд гэмт хэрэгт гурван жилээс дээшгүй хугацаагаар анх удаа хорих ял шийтгүүлсэн насанд хүрээгүй эрэгтэйчүүд, түүнчлэн хорих ял шийтгүүлсэн насанд хүрээгүй эмэгтэйчүүдийн хорих ялыг жирийн дэглэмтэй хүмүүжил-хөдөлмөрийн колонид эдлүүлэхээр оногдуулна./Энэ хэсгийг 1993 оны 6 дугаар сарын 7-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./

9.Урьд хорих ял эдэлж байсан, хүнд буюу онц хүнд гэмт хэрэг гурван жилээс дээш хугацаагаар хорих ял шийтгүүлсэн насанд хүрээгүй эрэгтэйчүүдийн хорих ялыг чанга дэглэмтэй хүмүүжил-хөдөлмөрийн колонид эдлүүлэхээр оногдуулна. /Энэ хэсгийг 1993 оны 6 дугаар сарын 7-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./

10.Гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, гэм буруутай этгээдийн хувийн байдал болон хэргийн бусад нөхцөл байдлыг харгалзан чанга дэглэмтэй засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн колонид ял эдлүүлбэл зохих онц аюултай гэмт хэрэгтнээр тооцогдоогүй этгээдийн хорих ялыг жирийн дэглэмтэй засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн колонид, түүнчлэн чанга дэглэмтэй хүмүүжил-хөдөлмөрийн колонид ял эдлүүлбэл зохих насанд хүрээгүй эрэгтэйчүүдийн хорих ялыг жирийн дэглэмтэй хүмүүжил-хөдөлмөрийн колонид эдлүүлэхээр шүүх тогтоож болно. Ийнхүү шийдвэрлэсэн шалтгааныг таслан шийдвэрлэх тогтоолд заана. /Энэ хэсгийг 1993 оны 6 дугаар сарын 7-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./

11.Онц аюултай гэмт хэрэгтнээр тооцогдоогүй боловч хүнд буюу онц хүнд гэмт хэрэгт арваас дээш жилийн хугацаагаар чанга дэглэмтэй засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн колонид ял эдлүүлбэл зохих этгээдийн ялыг гэмт хэргийн шинж чанар, хэр хэмжээ, гэм буруутай этгээдийн хувийн байдал болон хэргийн бусад нөхцөл байдлыг харгалзан онцгой дэглэмтэй засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн колонид эдлүүлэхээр шүүх тогтоож болно. Ийнхүү шийдвэрлэсэн шалтгааныг таслан шийдвэрлэх тогтоолд заана. /Энэ хэсгийг 1993 оны 6 дугаар сарын 7-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./

12.Онц аюултай гэмт хэрэгтнээр тооцогдсон болон арван найман насанд хүрсний дараа төрийн эсрэг онц аюултай гэмт хэрэг үйлдсэн этгээд, түүнчлэн арван найман насанд хүрсний дараа энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан бусад хүнд буюу онц хүнд гэмт хэрэг үйлдэж таван жилээс дээш хугацаагаар хорих ял шийтгүүлж байгаа этгээдийн хорих ялыг бүгдийг буюу заримыг гянданд эдлүүлэхээр шүүх тогтоож болно. /Энэ хэсгийг 1993 оны 6 дугаар сарын 7-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./

13.Ялтан ял эдлэх засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн байгууллагын төрөл, дэглэмийг Монгол Улсын хууль тогтоомжид заасан үндэслэл, журмаар шүүх өөрчилнө.

23 дугаар зүйл.Онц аюултай гэмт хэрэгтэн

1.Дараахь этгээдийг шүүх онц аюултай гэмт хэрэгтнээр тооцно:

а/хүнд гэмт хэрэг үйлдэж, урьд нь хорих ялаар хоёр удаа шийтгүүлж, уг ялаа эдэлж байхдаа буюу эдэлсний дараа дахин хүнд гэмт хэрэг үйлдэж, хорих ялаар шийтгүүлсэн этгээд;

б/хүнд буюу онц хүнд гэмт хэрэг үйлдэж урьд нь хорих ялаар шийтгүүлж, уг ялаа эдэлж байхдаа буюу эдэлсний дараа дахин хүнд гэмт хэрэг үйлдэж хорих ялаар шийтгүүлсэн этгээд;

в/урьд нь хорих ялаар шийтгүүлж байгаагүй боловч удаа дараа онц хүнд гэмт хэрэг үйлдэж хорих ял шийтгүүлсэн этгээд.

2.Онц аюултай гэмт хэрэгтнээр тооцоход болон давтан үйлдсэн гэмт хэргийн тоонд энэ хуулиар тогтоосон журмаар ял шийтгэлгүйд тооцсон буюу ял шийтгэлгүй болсныг оруулан тооцохгүй.

3.Онц аюултай гэмт хэрэгтний үйлдсэн гэмт хэрэгт хариуцлага хүлээлгэхээр заасан энэ хуулийн тусгай ангийн зүйлийг уг этгээд тухайн гэмт хэргийг үйлдэхээс өмнө хуульд заасан журмаар онц аюултай гэмт хэрэгтнээр тооцогдсон тохиолдолд хэрэглэнэ.

4.Шүүх тухайн этгээдийг онц аюултай гэмт хэрэгтнээр тооцох болсон үндэслэлээ таслан шийдвэрлэх тогтоолд заана.

5.Онц аюултай гэмт хэрэгтнээр тооцсон нь уг этгээдийг ял шийтгэлгүйд тооцсон буюу тухайн этгээд ял шийтгэлгүй болсон үед хүчингүй болно.

[/Энэ зүйлийг 1993 оны 6 дугаар сарын 7-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

24, 25, 26 дугаар зүйл./1993 оны 6 дугаар сарын 7-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон./

27 дугаар зүйл.Засан хүмүүжүүлэх ажил хийлгэх

1.Засан хүмүүжүүлэх ажил хийлгэх ялыг гурван сараас нэг жил зургаан сар хүртэл хугацаагаар оногдуулж, шүүхийн таслан шийдвэрлэх тогтоолын дагуу ялтны ажиллаж байгаа газарт, эсхүл засан хүмүүжүүлэх ажил хийлгэх ялыг биелүүлэх байгууллагын заасан, оршин суугаа газарт нь ойролцоо өөр газарт эдлүүлнэ.

2.Ялтны цалин хөлсний арваас хорин тав хүртэл хувийн дотор шүүхийн таслан шийдвэрлэх тогтоолд заасан хэмжээгээр суутган, улсын орлогод оруулна.